

**Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан 29/03 тоот дотоод аудитын ажлын удирдамжийн дагуу Хархорин Ус суваг ОНӨААТҮГазрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.**

**1. Аудитын зорилго:**

Хархорин Ус Суваг ОНӨААТҮГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх зорилготой.

**2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:**

Хархорин Ус Суваг ОНӨААТҮГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдсөн тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмжүүд
<b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу дуудлагын үйлчилгээний үнэ тарифыг тогтоосон эрх зүйн акт байхгүй.</b>	1. Байгууллагынхаа ТУЗөвлөлд дуудлагын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох талаар эдийн засгийн тооцоо судалгааг хийн, асуудал оруулах 2. ТУЗ-ийн шийдвэр, холбогдох хуулийн заалтуудыг үндэслэн дуудлагын үйлчилгээний үнэ тарифыг тогтоосон захирлын тушаал гаргах, үүнийгээ сумын хэмжээнд мөрдөн ажиллах 3. Дуудлагын үйлчилгээний үнэ тарифыг тогтоосон эрх зүйн баримт бичгийг байгууллагынхаа цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх
<b>Анхан шатны тайлан гаргаагүй, техник ашиглалтын паспортын хөтлөлт бүрэн гүйцэд бус</b>	1. Бараа материалын нэр төрөл бүрээр агуулахын бүртгэлийг хөтлөн, орлого, зарлагын хөдөлгөөнийг хийж, бараа материалын тайланг гарган нягтлан бодогчоор хянуулахдаа агуулахын үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байх 2. Бичиг хэргийн материал, аж ахуйн материал, шатахууны тайлан зэрэг бараа материалын тайланг батлагдсан маягтаар улирал бүр нэр төрлөөр нь дэлгэрэнгүй гарган, нягтлан бодогчид хүлээлгэн өгч, хянан баталгаажуулж байх

	<p>3.Бараа материалын үлдэгдэлд тооцоо бодсон актыг үйлдэж хэвших</p> <p>4.Автотээврийн хэрэгслийн техник ашиглалтын паспортад авсан, зарцуулсан шатахуун болон машин механизмын гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд бичилтийг хийж хэвших</p>
<p><b>Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.</b></p>	<p>1.Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох</p> <p>2.Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх</p> <p>3.Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах</p> <p>4.ТУЗ, аймгийн Засаг даргатай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх</p> <p>5.Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах</p> <p>6.Эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах</p> <p>7.Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах</p> <p>8.Нэгээс доошгүй албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах</p> <p>9.Байгууллагын эрсдэлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх</p>
<p><b>Дотоод хяналтын нэгж эрсдэлд чиглэсэн хяналтыг хийдэггүй, байгууллагын гүйцэтгэж байгаа үйл ажиллагаагаануудыг дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд тусгадаг.</b></p>	<p>1.Дотоод хяналтын нэгжийн журам болон дүрэм гэж тус тусад нь гаргасныг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн, нэг журамтай болж мөрдөн ажиллах</p> <p>2.Журмандаа дотоод хяналтын нэгжид ажлыг сайжруулах талаар тусгаж, ажлыг үнэлэн, биелэлтийг тоохон хууль тогтоомжид нийцсэн урамшууллын хөшүүргийг тусгаж өгөх</p> <p>3.Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх</p> <p>4.Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх</p> <p>5.Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх</p>